


# ХИМИЙН ХОРДЛОГЫН НӨХЦӨЛ БАЙДЛЫН 7 ХОНОГИЙН МЭДЭЭ


## НЭГ. Угаарын хийн цочмог хордлогын мэдээ

Нийгмийн эрүүл мэндийн үндэсний төвийн Хор судлал, шуурхай удирдлагын албанд 2024 оны 12 дугаар сарын 29-ний өдрөөс 2025 оны өдрөөс 08 дугаар сарын 30-ны өдрийн байдлаар буюу **эпидемиологийн 1-35 дугаар долоо хоногт** нийт Нийслэлийн 7 дүүрэг, 8 аймагт **1379** хүн угаарын хийн хордлогын улмаас эмнэлгийн тусламж үйлчилгээ авсан.



### Угаарын хийн хордлогод өртсөн иргэдийг байршлаар авч үзвэл:

Угаарын хийн хордлогод өртсөн 1379 тохиолдлын 94% /1299/ нь Улаанбаатар хотод бүртгэгдсэн бол, 6% /80/ нь орон нутагт (Баян-Өлгий /30/, Дорнод /3/, Орхон /11/, Өмнөговь /9/, Сэлэнгэ /6/, Төв/16/, Дорноговь /4/, Баянхонгор /1/ ) бүртгэгдсэн байна.




Нийслэлд угаарын хийн хордлогод өртсөн тохиолдлыг дүүрэг тус бүрээр авч үзвэл хамгийн өндөр буюу **370** тохиолдол Сонгинохайрхан дүүрэгт бүртгэгдсэн байна.

ЭПИДЕМИОЛОГИЙН **35** ДУГААР ДОЛОО ХОНОГТ

(2025.08.24 – 08.30)


2025 оны эпидемиологийн 35 дугаар долоо хоногт 3 угаарын хийн хордлого бүртгэгдсэн байна. Өмнөх оны мөн үеэс 66.7 хувь, 5 жилийн дунджаас 73.3 хувиар тус тус буурсан үзүүлэлттэй байна.



## ХОЁР. Бусад химийн бодисын цочмог хордлогын мэдээ


Цэргийн төв эмнэлгийн харьяа Хордлогын яаралтай тусламжийн үндэсний төв, Эх хүүхдийн эрүүл мэндийн үндэсний төвд **эпидемиологийн 1-35 дугаар долоо хоногт нийт 891** иргэн химийн цочмог хордлогын улмаас эмнэлгийн тусламж үйлчилгээ авсан байна.

|                                                |                                                |                        |                       |                       |
|------------------------------------------------|------------------------------------------------|------------------------|-----------------------|-----------------------|
| <b>511</b><br>Эмнэлэгийн<br>тусламж авч буцсан | <b>380</b><br>Хэвтэн эмчлүүлж<br>эдгэрч гарсан | <b>0</b><br>Нас барсан | Эрэгтэй<br><b>45%</b> | Эмэгтэй<br><b>55%</b> |
|------------------------------------------------|------------------------------------------------|------------------------|-----------------------|-----------------------|



Химийн хордлогыг насны бүлгээр авч үзвэл 0-9 буюу бага насны хүүхдүүд хамгийн их хордлогод өртөж байна.

2025 оны **эпидемиологийн 35 дугаар долоо хоногт** химийн цочмог хордлогод өртсөн **27** хүн хандаж эмнэлгийн тусламж үйлчилгээ авсан байна. Энэ үзүүлэлт нь өмнөх оны мөн үеээс 58.8 хувиар, сүүлийн 5 жилийн дунджаас 2 дахин өссөн үзүүлэлттэй байна.



Хүснэгт 1. Химийн цочмог хордлого, шалтгаанаар (Эпи – 35 долоо хоногт)

| №    | Шалтгаан (Сэдэл)        | Санаатай | Санамсаргүй | Нийт |
|------|-------------------------|----------|-------------|------|
| 1    | Химийн бодисын хордлого | 1        | 12          | 13   |
| 2    | Эмийн хордлого          | 4        | 10          | 14   |
| Нийт |                         | 5        | 22          | 27   |

Эмийн хордлого нийт тохиолдлын талаас илүү хувийг эзэлж байна. Санаатай хордлого нь эмийн хэрэглээнээс голчлон шалтгаалдаг бол, химийн бодисын хордлого ихэнхдээ санаандгүйгээр тохиолддог байна.

Урьдчилан сэргийлэхийн тулд:

Гэр ахуйн болон үйлдвэрийн химийн бодисын хадгалалт, хэрэглээнд хяналт тавих.

Эмийн хэрэглээг хянах, илүүдэл хэрэглэхээс сэргийлэх, ялангуяа хүүхэд, өсвөр насныханд анхаарах шаардлагатай.

-оОо-